

## Агуулга

1. Төслийн товч танилцуулга.....	2
2. Байгаль орчны суурь судалгаа.....	5
3. Байгаль орчны төлөвлөгөөний зорилго.....	8
4. Төслийн талбайн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	10
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	13
7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	16
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	18
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..	18
10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	18
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	18
12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	20
13. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт.....	21
14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт.....	21
15. Байгаль орчинд зарцуулсан төсөв.....	23
16. Дүгнэлт.....	25

## Хавсралт

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө
3. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
4. Ус ашиглах дүгнэлт
5. Ус ашиглах гэрээ
6. Усны төлбөр төлсөн баримт
7. Мониторингийн судалгаа шинжилгээний хариу
8. Хог хаягдалын гэрээ
9. Биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх төлөвлөгөө, гүйцэтгэл
10. Байгаль орчны аудитын зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан
11. Өгөөмөр MV-001329 талбайн БОХ-3 р маягт
12. Өгөөмөр MV-008866 талбайн БОХ-3 р маягт
13. Өгөөмөр MV-013205 талбайн БОХ-3 р маягт
14. Өгөөмөр уурхай БОХ-7
15. Нөхөн сэргээлт хүлээн авсан акт
16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

## НЭГ. ОРШИЛ

Хос Хас ххк нь Булган аймгийн бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт орших MV-008866 , MV-013205, MV-001329 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Өгөөмөр ордыг эзэмшидэг бөгөөд 2023 онд тус талбайн В-3 В-5 В-6 С-1 блокуудад ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор ашигт малтмал газрын тосны газраар үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан тус төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан болно. Төлөвлөгөөт онд дээрхи блокуудын хүрээгээр нийт 32.28 га талбайд 7642.78мян.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж 324.1мян.м3 элс олборлон баяжуулахаар төлөвлөсөн төлөвлөсөн бөгөөд 10 дугаар сарын байдлаар ажлын гүйцэтгэл 69хувийн биелэлттэй байна . Цаашид төлөвлөгөөт онд 11 дүгээр сарыг дуустал үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1 Төслийн байршил :

“Хос Хас” ХХК-ийн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Өгөөмөрийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос 297 км, Дархан Уул аймгаас 185 км, Эрдэнэт хотоос 180 км, Булган аймгийн төвөөс 130 км, Бүрэгхангай сумаас 77 км, Хайлаастын алтны уурхайгаас 48 км-т, 1329А, 8866А, 13205А тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудыг дамнан байрладаг.

### Хүснэгт 1.

#### Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

№	Солбицол уртраг/өргөрөг	№	Солбицол уртраг/өргөрөг	№	Солбицол уртраг/өргөрөг
1	104°31'14,5" 48°25'9,47"	20	104°30'1,02" 48°23'51,83"	39	104°29'23,94" 48°24'44,81"
2	104°31'14,8" 48°24'40,33"	21	104°29'35,95" 48°23'51,8"	40	104°29'23,94" 48°24'51,8"
3	104°31'5,03" 48°24'40,29"	22	104°29'35,95" 48°23'8,82"	41	104°29'32,95" 48°24'51,8"
4	104°31'5,17" 48°24'25,72"	23	104°29'24,45" 48°23'8,82"	42	104°29'32,95" 48°24'58,8"
5	104°30'55,43" 48°24'25,68"	24	104°29'24,45" 48°23'15,31"	43	104°29'43,95" 48°24'58,8"
6	104°30'55,54" 48°24'14,35"	25	104°28'57,95" 48°23'15,31"	44	104°29'43,95" 48°25'9,8"
7	104°30'41,04" 48°24'14,29"	26	104°28'57,95" 48°22'51,81"	45	104°30'1,02" 48°25'9,83"
8	104°30'41,04" 48°24'16,84"	27	104°28'30,95" 48°22'51,81"	46	104°30'1,02" 48°25'15,83"
9	104°30'01,02" 48°24'16,84"	28	104°28'30,95" 48°23'6,81"	47	104°30'37,03" 48°25'15,83"
10	104°30'1,02" 48°24'41,83"	29	104°28'37,95" 48°23'6,81"	48	104°30'37,03" 48°25'25,84"
11	104°29'42,95" 48°24'41,8"	30	104°28'37,95" 48°23'24,81"	49	104°31'6,02" 48°25'25,83"
12	104°29'42,95" 48°24'29,8"	31	104°28'57,95" 48°23'24,81"	50	104°31'6,02" 48°25'34,84"
13	104°29'33,96" 48°24'29,8"	32	104°28'57,95" 48°24'24,8"	51	104°31'14,03" 48°25'34,82"
14	104°29'33,96" 48°24'21,81"	33	104°29'4,95" 48°24'24,8"	52	104°31'14,83" 48°25'51,7"
15	104°29'27,95" 48°24'21,81"	34	104°29'4,95" 48°24'29,8"	53	104°31'38,4" 48°25'51,65"
16	104°29'27,95" 48°24'3,8"	35	104°29'8,95" 48°24'29,8"	54	104°31'38,53" 48°25'38,7"
17	104°29'51,95" 48°24'3,8"	36	104°29'8,95" 48°24'36,8"	55	104°31'23,94" 48°25'38,64"
18	104°29'51,95" 48°24'11,81"	37	104°29'16,95" 48°24'36,8"	56	104°31'34,2" 48°25'9,51"
19	104°30'1,02" 48°24'11,84"	38	104°29'16,95" 48°24'44,81"		



*Зураг-1 Төслийн байршиллын зураг 1.2*

**Дэд бүтцийн объектууд**

*Ус хангамж:* Байгаль орчныг бохирдуулахгүй байх, усыг хэмнэлттэй зарцуулахын тулд усан хангамжийг битүү циклээр буюу усан сан байгуулан ажиллана. Усан сангийн нийт багтаамж 200000м<sup>3</sup> бөгөөд ууршилт, хөрсөн дэх шингэлтээс үүсэх усны алдагдал нь хөрснөөс нэвчин ирэх усаар нөхөн сэлбэгдэж байна. Дээрхи усан сангийн ус хоногт 3000м<sup>3</sup>-ээр тэжээгдэж байдаг болно.

Усан сангаас Д-320/50 насосоор угаах төхөөрөмжид ус шахаж өгнө. Нийт усан хангамжийн эргэлтийн хувь 75 орчим хувьтай байна.



*Зураг 2. Худгийн барилга,*

**1.3 Цахилгаан хангамж:**

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлаж буй 2\*10000кВА чадалтай 110/35/6кВ-ын Баясаглант дэд станцаас Өгөөмөрийн алтны уурхайд хагийн ойр 17км-т орших дэд станц нь юм. Иймд уурхайг эрчим хүчний эх шшсвэртэй холбох зорилгоор Баясаглант дэ станцаас Заамар сумын Өгөөмөр тосгоныг холбосон сүлжээнээс 35кВ-ийн өндөр хүчдэлийн шугамыг шинээр татан, улсын эрчим хүчний системд холбогдсон . Уурхайд 44кВт чадалтай Sreen -80м<sup>3</sup> маркийн элс угаах төхөөрөмж 2ш, 25кВт чадалтай шахах Д-280/75 носас, Д-320/90 маркийн ус татах 2 ширхэг носас, 18кВт чадалтай QJ-110PE маркийн гүний худгийн носас , уурхайн гэрэлтүүлэг, засварын цех, граш, үйлдвэрийн талбай, уурхайн захиргаа, ажилчидын байр зэрэг цахилгаан хэрэглэгчид нь 0,4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдсан болно.

**1.4 Хүчин чадал, техник технологи**

Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн үзүүлэлт, тус ордод хийсэн лабораторийн шинжилгээний үр дүн /алтны 57,03% нь -0,63 мм-+0,16 мм/ зэргийг харгалзан эргэлтэт скруббер ба шлюзийн хослол бүхий баяжуулах төхөөрөмжөөр ялган авдаг. Алттай давхаргаас олборлосон элсийг угаах төхөөрөмжинд усан буугаар буудаж хийхэд хүлээн авах торон дээр +100 мм-ийн том чулуунууд ялгаран хаягдаж, -100 мм нь эргэлтийн шигшүүрт угаагдан +20 мм, -20 мм-ийн хэмжээтэй ангилагдана. -20 мм нь ахин ангилагдаж +5 мм, -5 мм хэмжээтэй ангилагдана. Угаагдаж байгаа элсний +20 мм, +5 мм-ийн хэмжээтэй нь хуурай хаягдалд овоологдон бульдозероор түрэгдэн овоологдох ба -5 мм хүртлэх мөхлөгүүд нь шлюзэд тунан угаагддаг.

Баяжуулж байгаа технологи нь элсний ашигт эрдсийг аль болох өндөр хувиар ялган авах зорилготой бөгөөд үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар шийдэгдсэн байна.

### ***1.5 Уул технологийн хэсэг***

Уг орд нь ашиглалтын гүн их 29,0метр , уул геологийн нөхцөл харьцангуй энгийн тул үндсэн хөрс хуулалтын ажлыг Хос Хас ХХК нь komatsu PS-1250, PS-600-2ш Doosan PS-500-3ш HD465, Норд , Тонли маркийн автосамосвал, ковш зэрэг техник тоног төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэсэн . Комацу , Норд , Тонли маркийн автосамосвал, ковш зэрэг техник тоног төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэсэн . Комацу ,Doosan экскаваторын тусламжтай ухаж шидэх , шилжүүлэн зөөх болон ТОНЛИ маркийн автосамосвалын хослолоор тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигласан ба хөрсний овоолгыг гадаад дотоод овоолгоор хийж гүйцэтгэв. Элс олборлолтын ажлыг тээвэртэй системээр гүйцэтгэж Sreen-80 угаах төхөөрөмжийн тусламжтайгаар баяжуулав. Хос Хас ХХК-ын Өгөөмөр уурхай нь улиралын шинж чанартай тул Өгөөмөр уурхайд 04-р сараас 12 сар хүртэл үйл ажиллагаа явуулана.

## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт Орхон Туулын бэлчирт, Туул голын доод хэсэгт оршино. Туул голын сав газар нь далайн түвшинээс харьцангуй өндөр өргөгдсөн, далай тэнгисийн алслагдсан, эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн тул өдөр шөнийн агаарын температурын ялгаа их хүйтэний улирал харьцангуй урт харин зун богино хур тундасны ихэнхи хувь нь дулааны улиралд орох бөгөөд ихэвчлэн агаарын тогтворгүйжилээс үүдэн конвекцийн гаралтай байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн сар нь 1-р сард  $-37^{\circ}\text{C}$ - $40^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан сар нь 7-р сард агаарын температур  $+32^{\circ}\text{C}$  хүрдэг.

Хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангай их мужийн Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Орхон-Шаамарын хөрсний тойрогт тус тус хамрагдаж байна. Тусгай зөвшөөрөлтэй талбайнуудаар Хөнгөн шавранцар доор карбонаттай Хар хүрэн, Сайргархаг, карбонаттай хөнгөн шавранцар Хар хүрэн хөрс, хөнгөн шавранцар хүрэн хөрс зэрэг 3 хэв төрлийн хөрс тархсан байна.

Ургамал-Газарзүйн мужлалын хувьд Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их муж чийглэгдүү хэв шинжийн Дорнод азийн муж Орхон-Туулын нам уулын тойрогт хамаарагдана. /Монгол улсын үндэсний атлас 2009 он/. Монгол орны Физик-Газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын сав бэсрэг уулсын муж Орхон Ерөө голын тойрогт багтана. Олборлолт явуулахаар төлөвлөж буй тусгай зөвшөөрөлтэй талбай нь нам уулсын уулын хээр, дэнжийн ургамалжилттай. Карбонаттай, хөнгөн шавранцар хүрэн хөрстэй дэнжийн хээр нь тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн хойд талаар голын дэнж хэсэгт орших ба үетэн-алаг өвст бүлгэмдэл тархана.

Ус зүйн хувьд нь Туулын сав газар орших бөгөөд тус сав газар нь Монгол орны амьтаны аймгийн газарзүйн мужлалаар /Банников 1954/ Монгол дагуурын хээрийн тойрог, Хангайн тойрог хооронд оршдог тул амьтаны аймгийн бүрэлдхүүний хувьд нилээд өвөрмөц бөгөөд баялаг байжээ. Түүнчлэн энэ бүс нутаг нь байгалийн хувьд олон янзын амьдрах орчныг өөртөө агуулсан учир ихээхэн онцлогтой. Жишээлбэл энд хээрийн үндсэн амьтад, голын сав газрыг түшин амьдардаг амьтад зонхилон тархсан байна. Энэ бүс нутагт Монгол оронд хаяагүй өргөн тархацтай, тоо толгойн хувьд ч элбэг тааралдах амьтдын төлөөлөгчид ч байдаг байжээ.

### 2.1 Уур амьсгал

Монгол орны уур амьсгал тус орны газарзүйн байршил онцлог, газрын гадаргын тогтоц, далайн төвшнөөс дээшхи өндөршлөөс шалтгаална. Өндөр уул, тэгш тал алаглан гадаргын байдал янз бүр байдаг явдал тухайн нутгийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг юм. Хуурайдуу сэрүүн зунтай, хүйтэн өвөлтэй. 1-р сарын дундаж  $-17^{\circ}\text{C}$ , 7-р сарын дундаж  $15.5^{\circ}\text{C}$ , жилийн дундаж салхины хурд 5-10м/сек, жилийн хур тундасны нийлбэр 300-400мм.

### 2.2 Хөрсний температур

2017 оны байдлаар хөрсний гадаргын температурын жилийн дундаж  $0.9^{\circ}\text{C}$  хүйтнээс  $4.7^{\circ}\text{C}$  дулаан ОЖД-тай харьцуулахад  $0.5$ - $1.7^{\circ}\text{C}$  хүйтэн, бусад нутгаар  $0.5$ - $2.1^{\circ}\text{C}$  дулаан байсан байна. Хөрсний гадаргын үнэмлэхүй их температур 8-р сард  $65.0^{\circ}\text{C}$  ба бусад нутгаар  $51.0$ - $61.7^{\circ}\text{C}$  хүрч халсан байна. Хөрсний гадаргын

үнэмлэхүй бага температур 11-р сард тус суманд 49.8<sup>0</sup>С, бусад нутгаар 35- 44.0<sup>0</sup>С хүрч хүйтэрсэн байна.

Хөрсний гадарга дээр өдөртөө 6-7 дугаар сард нийт нутгаар 60-68 градус, 8 дугаар сард ихэнх нутгаар 50-59 градус хүрч халсан байна.

**хүснэгт-2 Бүрэгхангай сумын температурын үзүүлэлт**

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Үзүүлэлт								I				
Дундаж температур °С	-21,9	-17,9	-3,7	4	11,9	17,1	16,7	15,9	7,5	1,2	-10,7	-19,2

**2.3 Хур тунадас**

Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Бүрэнхангай сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 0.3-1.6 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 2.5-5.3 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундажаас бага байна.

**2.4 Салхины горим**

Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 26, 15 м/с ба түүнээс

хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10-аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 25 м/с хүрч байсан.

Салхины жилийн дундаж хурд 1.4-4.0 м/с, хамгийн их хурд 15-28 м/с буюу аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 2-9, 11-12 дугаар саруудад салхины их хурд Булган, Хутаг, Сэлэнгэ, Могод, Гурванбулаг, Орхон, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын нутгаар 20-28м/с бусад нутгаар 12-17м/с хүрч салхилсан байна. 4- р сард Бүрэгхангай суманд салхины хурд 28 м/с хүрчээ.



Хүснэгт-3 Бүрэгхангай сумын салхины үзүүлэлт

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VI II	I X	X	XI	XII
Үзүүлэлт												
Салхины дундаж хурд, м/с	2.4	2.5	3.6	5.0	4.9	4.1	3.4	3.0	3.0	3.2	3.0	2.3
Их хурд, м/с	15	17	22	17	22	20	17	22	21	14	22	18

## 2.5 Ус зүй

Ус зүйн сүлжээ их бөгөөд умард мөсөн далайн ай савд багтна. Гол сүлжээний нягтшил 0.10-0.15 км/км<sup>2</sup> байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25мм-ээс дээш юм. Газар нутгийн чийгшил 200-250 мм, ууршилт 200-250мм жилийн дулаан үеийн ууршилт 600-800 мм гол мөрний усны булингар 100 г/м<sup>3</sup> –аас дээш. Хатуу урсац жилд 3 м/км<sup>2</sup> дээш. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10мм-ээс доош, зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 250мм орчим. Борооны үерийн хамгийн их урсацын модуль 0.2-ээс дээш байдаг.

## 2.6 Хөрс

Бүрэгхангайн сумын нутагт орших ба төслийн талбайн хамрах бөгөөд Хөрс-Газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Хангайн их мужийн, *Хархүрэн, хүрэн хөрсний дэд бүст, Орхон –Шаамрын 1-р тойрогт* багтана. Тус нутагт ихэвчлэн уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс зонхилж байдаг. Тухайн талбайд ерөнхийд уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс тогтворжсон.

## 2.7 Ургамлын нөмрөг

Монгол орны ботаник- газар зүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Дорнод азийн дэд мужийн Орхон-Туул нам уулсын хээрийн газарзүйн тойрогт хамаарагддаг. Тус бүс нутаг ихэнх нутгийг Уулын хээрийн тойргийн ургамалжилттай. Байгалийн бүс бүслүүрийн хувьд (А.А.Юнатовынхаар) Дундаж өндөр ба нам уулсын хээрийн бүсэд багтана. Тус бүс нутагт үндсэндээ чулуулаг алаг өвс- ботуульт хэв шинжүүдийн ургамжилт ихэвчлэн зонхилдог. Ургамал газарзүйн мужлалаар Хангайн уулын ойт хээрийн провинц, Сэлэнгийн уулын ойт хээрийн тойргийн Бүрэгхангайн районд хамрагдана. Уулс нь налуу мөлгөр энгэртэй, хавтгайдуу оройтой гол төлөв араараа шинэс хусан ойтой.

## 2.8 Амьтны аймаг

Ойн тархмал мэрэгчийн нэг хэрэм гол тэжээлээ дагаж хушин ойд хамгийн элбэг байна. Ойн зах унанги дархи, асга чулуутай хэсэгт жирх элбэг. Туурайтнаас бор гөрөөс, буга, зэрлэг гахай бүх ойт нугийн энгэрээр тархмал гэж болно. Аймгийн хамгийн хойд хэсэгт тайгын өндөр уулсын ар хажуугаар хүдэр нутаглана. Хантай,



Бүрэн, Бүтээлийн нуруугаар хандгай, хүрэн баавгай, булга, нохой зээх нутаглана. Агнуураас шалтгаалан булга нэг үе их ховордсон ч өсч байна. Уулын өмнөд өвөр хажуу бэл голын хөндийн ой модгүй задгай газарт идээшсэн олон зүйл амьтан бий. Энд 16-17 зүйл мэрэгч тохилдохоос тарвага, урт сүүлт зурам, сибирийн алга даага, үлийн цагаан оготно, үлийн бор оготно бусдаас элбэг байна. *Шавьж идэштнээс* дагуурын зараа, хонин малтаахай хоёр голын татам дэнж бэл хөндийгөөр тохилддог. Жижиг мэрэгч шувуу элбэг байгаа нь энд хярс, өмхий хүрэн зэрэг махан идэштэн олон байх нөгцөл болжээ. Хад чулуутай уулсаар мануул ховор биш үзэгдэнэ.

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

“Хос Хас” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

2023 онд тус төслийн үйл ажиллагаа 4 дүгээр сард эхлэсэн бөгөөд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

- Компанийн нийт ажилчдын байгаль орчны соёлыг өөрчлөх, экологийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг байгаль хамгаалах үйлст татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах, нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох зорилготой байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уурхай болох зорилго тавьж ажиллана.
- Нөхөн сэргээлтийн ажлын үр дүн бүтээмжийг сайжруулан биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартад нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэх.

### Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн

нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагварыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, зэргийг удирдлага болгов.

### ДӨРӨВ.ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт-4

Биосферийн элементүүд	Биосферийн элементүүдэд уулын үйлдвэрлэлийн үзүүлэх нөлөө	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	<ul style="list-style-type: none"> <li>Ус хангамжийн байгууламжийн шугам сүлжээг барих, ашиглах</li> <li>Элсний овоолго байгуулах /хөрс хуулах/</li> <li>Хаягдлын овоолго байгуулах;</li> <li>Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газрын гадаргуугийн деформаци, хөрсний эдэгдэл, талбайн дүр төрхийн өөрчлөлт</li> <li>Шатах тослох материалаар хөрс бохирдох</li> </ul>
Ус	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрийн усны хэрэглээ</li> <li>Ундны усны хэрэглээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газрын доорхи болон гадаргын усны нөөц, горим, чанар өөрчлөгдөх</li> </ul>
Агаар мандал	<ul style="list-style-type: none"> <li>Баяжуулах үйлдвэрээс гарах тоосжилт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Агаарын тоосжилт хорт хий ихсэх</li> </ul>
Ургамал	<ul style="list-style-type: none"> <li>Баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламж барих;</li> <li>Ус хангамжийн байгууламжийн шугам сүлжээг барих, ашиглах</li> <li>Хаягдлын овоолго байгуулах;</li> <li>Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ургамлан нөмрөг устах, ургамлын төрөл зүйл хомсдох, бэлчээрийн ургамал хомсдсоноос бэлчээрийн талбай багасах</li> </ul>
Амьтан	<ul style="list-style-type: none"> <li>Олборлолт, Баяжуулалтын үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрээс гарах дуу чимээ ихэссэнээс ан амьтан дайжих, байршил нь өөрчлөгдөх</li> <li>Туул голын ус бохирдсон тохиолдолд загас хордох</li> </ul>

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний хүрээнд дараахи арга хэмжээг авч ажиллаа.

**5.1. Агаар мандалд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Хөрс хуулалт, тээвэрлэлтийн явцад үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээ бол нэн түрүүнд зам талбайг услах явдал бөгөөд зам талбайг тогтмол усалж ажилладаг.

- Технологийн замыг тодорхой хөтөлбөрийн дагуу хайрга чулуу дэвсэж автогридерээр замыг хусаж тоос босох нөхцөлийг бууруулан, тогтмол усалгаа хийх зэргээр тоосыг багасгасан;
- Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторхи агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хөрс хуулалтын компанийн ХАБ-н ажилтны хамт тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллахыг автозасварын хэсэгт байсан;
- Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангасан;

**5.2 Усан орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- Үйл ажиллагааны явцад хөрсөн дээр шатах тослох материал асгаж гүний ус бохирдуулахгүй байх талаар сургалт, зааварчилгаагаар жолооч операторуудад хэвшүүлсэн.
- Уурхайн хотхон орчимд байрлах уст цэгүүдийн орчимд усны зохистой хэрэглээний талаархи мэдээллийн самбар байрлуулав.
- ОХШинжилгээний хөтөлбөрийн хүрээнд усны судлагаа шинжилгээг төлөвлөгөөт онд 2 удаа гүйцэтгүүлэв.

**5.3 Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр төрхөнд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- Компанийн ажилчид болон жолооч, операторуудад шатах тослох материал хөрсөн дээр хаяхгүй байх талаар байгаль орчны сургалт дээр суртачилдаг ба анхааруулах тэмдгийг зохих газар байрлуулсан болно. Мөн тос тосолгооны материал хөрсөнд нэвчүүлэхгүй байх зорилгоор хаягдал тос хадаглах цэгийг барьж тохижуулав.
- Уурхайн орчимд шинээр зам үүсгэхгүй байх зорилгоор зам талбайд тэмдэгжүүлэлтийг бүрэн хийж гүйцэтгэв.
- Нөхөн сэргээлтэнд ашиглагдах шимт хөрсийг шинжилгээнд өгч хадаглалтын горимд хяналт тавьж ажиллав.

Олборлолтын нийт ажилчидад шимт хөрс хуулах горимын талаар мэдээлэл олгох сургалт зохион байгуулав.

Төслийн талбайн хэмжээнд хөрсний мониторингийн судалгаа шинжилгээний ажил зохион байгуулж тухайн цэг бүрийг хатуу цэгээр тэмдэглэн тэмдэгжүүлэлт сэргээв.

#### **5.4 Ургамалын нөмрөгт үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Төлөвлөгөөт онд ургамалын нөмрөг хамгаалах зорилгоор дараахи ажлуудыг хийж гүйцэтгэв.

- Тоосжилт үүсч ургамалын нөмрөг доройтхоос урьдачлан сэргийлж зам талбайн усалгааг тогтмол хийж гүйцэтгэв.
- Уурхайн орчимд олон салаа зам гаргахгүй байх зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж засварлав.

### **ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.” MNS 5914-2008; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” /MNS 5915-2008/; ”Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт /MNS 5916-2008/; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/ стандартын дагуу төлөвлөгөөг гүйцэтгэсэн болно.

Өгөөмөр алтны уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөөгөөр төслийн талбайд нийт техникийн нөхөн сэргээлт 7.2 га талбайд , Биологийн нөхөн сэргээлт 3,4 га талбайд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн болно.

#### **6.1 Техникийн нөхөн сэргээлт**

Бид үйл ажиллагааны явцтай уялдуулан өмнөх жилүүдэд олборлолтонд өртөж нөхөн сэргээлт хийгдээгүй байсан талбайд дүүргэлтийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 14.8га талбайд дүүргэлтийн ажил гүйцэтгээд байна . Тус онд манай компани нь 12 дугаар сарын 01 хүртэл хугацаанд ажиллах бөгөөд дотоод дүүргэлтийн ажил үргэлжилж байгаа болно.



Зураг-11 ТНС-т хийгдэж буй явц

## 6.2 Биологийн нөхөн сэргээлт

Төлөвлөгөөт онд батлагдсан төлөвлөлтөөр нийт 3.0 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 оны 06 дугаар сард MV-001329, MV-013205 тусгай зөвшөөрлийн талбайд нийт 8,5 га хэсэгт бэлчээрийн олон наст үет ургамал холимогоор тариалсан бөгөөд 1га талбайд ногдох үрийн нормыг дундажаар 95 килограммаар тооцож тариаллаа. Талбайд тариалсан ургамалын соёололт 95 хувь бөгөөд ногоон масс бүрэн бүрхэж цаашид бие даан амьдрах боломжтой болсон гэж үзэж байна

### ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлага гарч байна. Иймд 2012 онд УИХ-аас баталсан Байгаль орчныг хамгаалах тухай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд дүйцүүлэн хамгаалах асуудлыг тусган өгч эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт байрлах орон нутгийн тусгай хэрэгцээний газарт нөлөөлөлд өртөж нөхөн сэргээлт хийгдээгүй талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэлээ.





Техникийн нөхөн сэргээлтийн ажил

### **НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Өгөөмөр уурхайн хэмжээнд малчидын өвөлжөө барилга байгууламж байрладаггүй тул тус хөтөлбөр нь хамааралгүй болно.

### **ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уг тусгай зөвшөөрлийн талбайд цаашид хийх геологи хайгуулын болон олборлолтын явц түүний дэд бүтцийн барилгажилтын ажил гарах нөхцөлд эртний түүх соёлын ямар нэгэн дурсгал өртөхөөргүй болсон тул **2023 онд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй** болно. Мөн цаашид ажлын явцад түүх соёлын өвийн ямар нэгэн илэрэл гарсан тохиолдолд холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэж хүндэтгэн харьцах болно.

### **АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Төлөвлөгөөнд тусгасны дагуу уурхай, үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахад цаг агаарын мэдээг хэрэглэж хэвшүүлж 7 хоног бүрийн цаг агаарын мэдээг мэдээллийн самбарт мэдээлдэг.

2023 оны аваар устгах төлөвлөгөө боловсруулж Онцгой байдлын газрын харьяа Уул уурхайн аврах ангиар батлуулсан бөгөөд энэ оны үйл ажилгааны туршид үүсэж болзошгүй аваар осол гарах тохиолдолд уг төлөвлөгөөг барьж ажиллахаар төлвөлсөн бөгөөд болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлж Хөдөлмөр хамгаалалын инженерийн хяналт сургалт тогтмол хэрэгжүүлж ажиллаа.

## **АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төлөвлөгөөт онд тус арга хэмжээний хүрээнд дараахи ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

- 2023 онд авто засварын хэсэгт байрлах тос тосолгоо хадаглах талбайг засаж сайжруулах ажлыг гүйцэтгэсэн .
- Ажилчидын ажил амралтын цагын хувиарт уялдуулан ажлын талбарт нийтийн цэвэрлэгээг хийж гүйцэтгэж хэвшсэн бөгөөд тус онд 2 удаа нийтийн цэвэрлэгээ хийж гүйцэтгэлээ
- Манай компани нь 2019 оноос эхлэн нийт ажилчин албан хаагчидад ХАБЭАБО хэсэг нэгжээр дамжуулах хариуцлагтай уул уурхайг хэвшүүлэх дадал хөтөлбөрийг хэрэгжүүлэн эхлэсэн бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд ажилчидад байгаль орчны мэдээлэл сургалтыг тогтмол өгч ажиллаа.

## **АРВАН ХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Өгөөмөрийн уурхай нь 2023 онд БОМТөлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхдээ дараах удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг барьж ажиллалаа.

- Монгол Улсын байгаль орчны багц хууль, журам болон стандартуудын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд төрийн захиргааны байгууллагуудын хяналт шалгалтаар нөхөн сэргээлтийн ажил эрчимжүүлэх зөвлөмж авч тухайн асуудалд нэн тэргүүний ач холбогдол өгч ажилласан болно.
- БОМТөлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу боловсруулж орон нутаг болон БОАЖЯаманд хүргүүлдэг болно.



- Байгууллагын байгаль орчныг хамгаалах талаарх бодлого болон төрөлжсөн дотоод журам 2023онд нэвтрүүлж ажилчидад эерэг хэвшил үүсгэх талд мэдээлэл өгч ажиллав.

**АРВАН ГУРАВ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ,  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан гаргаж мэдээллэж байсан болно. Бид төлөвлөгөөт онд уурхайн уурхайн бүсийн айл өрхүүдэд мэдээлэл олгох танилцуулах ажил хийж гүйцэтгэв.

**АРВАН ДӨРӨВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасны дагуу хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн бүр дээр хяналт шинжилгээг хийж гүйцэтгэлээ. ОХШинжилгээний хөтөлбөрийг 7 болон 10 дугаар сард ус хөрсний шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэсэн бөгөөд судалгаагаар “Өгөөмөр” уурхайн хэмжээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлөөс хүрээлэн буй орчинд зөвшөөрөгдөх стандартаас давсан үзүүлэлтгүй гарсан. Шинжилгээний хариуг хавсаргав.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ**

№	Хөтөлбөр	Төлөвлөлт сая.төг	Гүйцэтгэл сая төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3.5	1.7
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	0.5	ҮАЗ
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15	-
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	8.5	4.5
5	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр	5	31.6
6	Олон нийт тайлагнах хөтөлбөр	0.5	0.5
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3.0	5.1
	<b>Нийт</b>	<b>36.0</b>	<b>43.4</b>

## ДҮГНЭЛТ

“Хос Хас” ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Өгөөмөр шороон ордод олборлолт баяжуулалтын үйл ажиллагаа явуулахдаа хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, компанийн ажилчид болон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зорилго тавьж ажилладаг Бид төлөвлөгөөт онд нөхөн сэргээлт болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг оновчтой төлөвлөн бүрэн хэрэгжүүлэх зорилт тавин ажилласан бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал төлөвлөлт 36.0 сая төгрөг гүйцэтгэл 43.4 сая төгрөг байна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 тоот журмын дагуу боловсрууллаа.